

Монгол Улсын Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийх гол институт нь Үндсэн хуулийн хяналтын үндсэн багууллага болох “Үндсэн хуулийн Цэц” мөн болохыг энэ дашрамд онцлож байна.

АНУ-ЫН УЛС ТӨР ДЭХ БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТӨВҮҮДИЙН (THINK TANK) ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ ЯАГААД БОДЛОГЫН СУДАЛГАА ХЭРЭГТЭЙ ВЭ?

Д.Бадамдаш

.....

Тинк танк - Бодлогын судалгаа хийж, тодорхой шийдлийн хувилбарыг боловсруулан, санал болгож, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага гэж товчхон тодорхойлж болно. (Think tank гэсэн нэр томъёог бодлого судалгааны төв, хүрээлэн, бодлогын төв гэх мэтээр орчуулж болох мэт боловч нэр томъёоны зөрүүнээс зайлсхийж энэ хэвээр нь галиглан хэрэглэсэн болно.)

XX зууны эхэн үеэс АНУ-д түгэн дэлгэрсэн нь дараах хүчин зүйлстэй холбоотой гэж үздэг. Үүнд,

- улс төрийн намын болон намын сахилга бат сул хөгжсөн, улс төрийн тогтолцоо,
- филантропи (нийгэмдээ өгөх, туслах, хандив) үзэл санаа түгэн дэлгэрсэн 1870 онд саятан 100 байсан бол 1916 гэхэд 16 000 саятантай болсон. Үүнээс, нийгэмдээ өгөх үзэл санаа дэлгэрч, боловсрол, их сургууль, номын сан, эмнэлэг, музей, сангууд байгуулагдаж эхэлсэн.
- Төрийн үүргийг хязгаарлагдмал түвшинд зөвшөөрөх, засаг захиргааны үйл ажиллагааг байнга шалгаж, нягтлах эрмэлзэл хүчтэй байдаг,
- Улс төрч, албан хаагчдаас хараат бус экспертүүдийн үнэлэлт, саналыг харгалзах сонирхол хүчтэй байдаг зэрэг холбогдоно.

Яагаад хэрэгтэй гэж?

Хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын аппарат дахь бодлого боловсруулах чадамж илүү боловсронгуй болсон ч гэсэн тинк танкуудын судалгааг үнэлж үзэх дараах үндэслэл байдаг. Нэгт, засгийн газрын түвшинд тогтсон хандлагыг “эвдсэн” бүтээлч санал бага гардаг байхад, тинк танкууд илүү холыг харсан бодитой судалгаа гаргаж чадна гэж үздэг. Хоёрт, дээрхтэй холбоотойгоор засаг захиргааны түвшинд стандартчилагдсан горимын дагуу “явцуу” хүрээнд шийдэл гаргадаг бол тинк танкууд өөрчлөлтийг зоригтой санал болгож чаддаг аж. Гуравт, тинк танкууд сонирхлын зөрчлөөс ангид шинжээчдийг бүрэн дайчилж, хамтран ажиллах бүтэц бий болгож чаддаг давуу талтай гэж үздэг (McGann, 2005).

АНУ-ын улс төрд гүйцэтгэдэг үүрэг

Дээрхээс үзвэл, тинк танкууд нь бодлогын хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлэх, өмгөөлөл, нөлөөллийн ажиллагаа явуулах үүрэгтэй гэж үзэж болох боловч тинк танкуудтай уулзаж үзэхэд АНУ-ын улс төрд үүнээс илүү өргөн хүрээтэй үүрэг гүйцэтгэдэг гэж ажиглагдав. Үүнд,

- Хүний нөөцийн бэлтгэл, хангалт хийдэг. Шинэ засаг захиргаа гарч ирээд холбооны засгийн бүтцийн удирдлага, бодлого боловсруулагчдыг тинк танкуудын судлаач, экспертүүдийг авч ажиллуулдаг.
- Сөрөг хүчний байр суурь, эсрэг хувилбарыг дэвшүүлэн засгийн газарт үр дүнтэй шүүмжлэл өрнүүлдэг. Тинк танкууд өмнөх засаг захиргаанд ажиллаж байсан

туршлагатай, холбоо сүлбээтэй, эх сурвалжтай экспертүүдийг мөн ажиллуулах сонирхолтой байдаг. Ингэснээр бодлогын нөхцөл байдлын талаарх хангалттай мэдээлэлт экспертүүдээр бодлогын альтернатив шийдлийг боловсруулдаг. Ингэснээр, сөрөг хүчин нь тинк танкуудаар дамжуулан сүүдрийн засгийн газрын үүрэг гүйцэтгэх боломжтой.

- Медиа контент бүтээхэд чухал үүрэгтэй. Бодлогын ялгаатай шийдлүүдийг Засгийн газрын хувилбартай харьцуулах, үнэлэх хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд тинк танкууд идэвхтэй оролцдог нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн чанар, нэр хүндийг өсгөдөг. Контент нь бодлогын шийдэлд анхаарснаар иргэдийн улс төрийн боловсролд чухал үүрэгтэй төдийгүй, улс төрийн хэлэлцүүлэг, мэтгэлцээн нь хувь хүний асуудалд тулгуурласан дуулиан хөөхөөс илүү бодлогын шийдэл тойрсон шинжтэй болдог нь улс төрийн соёлын төлөвшилд чухал үүрэгтэй.
- Улс төрийн голлох хоёр намын хувьд эрх бариагүй үедээ ч хүний нөөцийн бэлтгэл байнга хангагдан шинэ захиргаа шилжилт хийхэд хялбар болж, залгамж халаа болон шинэ бодлогын уялдаа холбоо сайжирдаг.
- Улс төрийн өрсөлдөөн, тэмцэл нь бодлогын хувилбарын өрсөлдөөн болдог. Улс төр нь ажил хэрэгч, сонгогчдын сонголт нь бодлогын сонголт болдог. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд үндэслэлтэй судалгаа бүхий бодлогын хувилбарын талаар олон талаас нь задлан шинжлэх, холбогдох экспертүүдийг дайчлах боломж олгодог.

Ангилал

Судлаач Жэймс Макган тинк танкуудыг олон шалгуураар ангилж үзсэн байдаг (2005). Зохион байгуулалтын төрлөөр нь

1. Ерөнхий эрдэм шинжилгээний чиглэлийн тинк танкууд.
 - Экспертүүд нь эрдэмтэд голдуу байдаг бөгөөд эрдэм шинжилгээний судалгаанд тулгуурладаг. Оюутангүй их сургууль байдаг бөгөөд тодорхой шинжлэх ухааны салбар, чиглэлийг баримталж ажилладаг.
 - Судалгаа нь урт хугацааг харсан байдаг
 - Хараат бус, объектив шалгууртай
 - Урт, дэлгэрэнгүй судалгаа, эрдэм шинжилгээний өгүүлэл, нэг сэдэвт судалгааны бүтээл гаргадаг

Ийм байгууллагын жишээ гэвэл Брукингс Институшн (The Brookings Institution), Американ Энтерпрайз Институт (American Enterprise Institute), Стратеги Олон улс судлалын төв (Center for Strategic and International Studies) зэрэг орно.
2. Эрдэм шинжилгээний тусгай чиглэлийн тинк танк. Бүтэц, үйл ажиллагааны хувьд дээрхтэй төсөөтэй боловч эдийн засаг, нийгмийн халамжийн шинэчлэл гэх мэт тодорхой нэг сэдэв, чиглэлийг онцолдог.
 - Тодорхой чиглэлийн асуудлаар ахисан шатанд гүнзгийрүүлэн судалдаг.
 - Судалгааны чиглэл тодорхой, түүнийг дагасан санхүүжилт, үйлчлүүлэгчид нь хязгаарлагдмал.

Жишээ: Эдийн засгийн судалгааны үндэсний товчоо (National Bureau of Economic Research), Хамбургийн эдийн засгийн судалгааны хүрээлэн (Hamburg Institute for Economic Research).
3. Гэрээт судалгаа, зөвлөгөөний байгууллагууд. Төрийн байгууллагын захиалга, санхүүжилтээр судалгаа, дүн шинжилгээ, зөвлөмж боловсруулдаг байгууллагууд.
 - Тодорхой чиглэлүүдээр мэргэжсэн байдаг.
 - Судлаачдын хувьд хязгаарлагдмал эрх чөлөөтэй.
 - Судалгаа гэхээсээ илүү бодлогын шинжилгээнд илүү анхаардаг.

- Зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагын бүтэцтэй байдаг. Үүний жишээнд, Рэнд корпорац, (RAND Research and Development) батлан хамгаалах чиглэлээр зөвлөгөө өгдөг, одоо илүү өргөн чиглэлд гэрээний үйлчилгээ үзүүлдэг. Урбан Институт (Urban Institute) үүний нэг жишээ. Ийм төрлийн байгууллага, төв, хүрээлэнгүүд Монголд ч мөн өргөн дэлгэрсэн. Тухайлбал, Нээлттэй нийгэм форум, СИКА, (Статистик, социологийн судалгааны төв) зэрэг байдаг.
4. Нөлөөллийн тинк танк. Тодорхой байр сууринаас асуудлыг хөндөж, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд илүү улс төрийн өнгө аястай байдаг.
- Тодорхой үзэл суртал, их үйлс, зорилготой
 - Хүн амын дунд өөрийн үйлчилдэг бүлэг, сегменттэй.
 - Намын улс төрийн үйл ажиллагаатай уялдаатай.
 - Тодорхой асуудлаар хууль, бодлогод өөрчлөлт оруулах эрмэлзэлтэй
Жишээ нь, Эрүүл эдийн засгийн төлөөх иргэд (Citizens for a Sound Economy), болон КАТО хүрээлэн (the CATO Institute) зэрэг болно.
5. Бодлогын бизнес зарчимтай байгууллагууд нь өөрийн үзэл санааг менежментийн арга барилаар боловсруулж, сурталчлах сонирхолтой байдаг.
- Корпорацийн үр ашигтай бүтэц, зохион байгуулалттай байдаг.
 - Менежмент, маркетинг, борлуулалтын зарчмуудыг бодлогын судалгаанд ашигладаг.
 - Эрдэм шинжилгээний шинжтэй бодлогын судалгаа нь бодитой хэрэгцээ хангадаггүй гэж үздэг.
 - Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, улс төрчдийн хэрэгцээнд нийцүүлж бодлого боловсруулах ёстой гэдэг.
 - Богино хэмжээний, энгийн хэллэгтэй зөвлөмж гаргаж, тулгамдсан асуудалд түлхүү анхаардаг.
 - Яаралтай асуудалд хариу өгөх, шийдэл боловруулахад анхаардаг.
Жишээлбэл, Хэритэж Сан (Heritage Foundation), Эдийн засгийн бодлогын хүрээлэн (Economic Policy Institute) гэх мэт.

Өөр нэг чухал шинж бол ерөнхий үзэл суртлын байр сууриар нь ангилж үзэх нь чухал байдаг. Учир нь үзэл суртлын өнцөг судалгааны чиг хандлагаас гадна дүгнэлтэд нөлөөлдөг. Нэг талаас консерватив буюу чөлөөт зах зээлийн эдийн засгийн болон уламжлалт нийгмийн бодлогыг дэмждэг байхад либертар тинк танкууд эдийн засгийн хувьд адил бодлоготой боловч нийгмийн бодлогын хувьд төрийн зохицуулалтыг эсэргүүцдэг аж. Прогрессив тинк танкууд эдийн засгийн бодлого дахь төрийн зохицуулалт, оролцоог таашаадаг боловч нийгмийн бодлогын хувьд олонх нь төрийн оролцоог бууруулахыг дэмждэг. Төвч байр суурьтай тинк танкууд консерватив болон прогрессив байр суурийн дундыг барих гэж үздэг байна.

Үзэл суртлын чиг баримжаагаар нь тинк танкуудыг ингэж ангилж үзэж болно.

Консерватив	Либертар	Баруун төв	Төвч	Зүүн төв	Прогрессив
Хэритэйж сан	Рйизон Сан	Вашингтоны Ойрхи дорнын бодлогын хүрээлэн	Олон улсын эдийн засгийн хүрээлэн	Хотын хүрээлэн	Татварын шударга ёсны төлөөх иргэд
Американ энтерпрайз хүрээлэн	Като хүрээлэн	РЭНД корпораци	Милкэний Хүрээлэн	Картер төв	Америкийн дэвшил төв
Хадсон хүрээлэн		Стратеги, Олон улс	Эдийн засгийн судалгааны	Брукингс Институшн	Шударга ёсны бодлогын хүрээлэн

		судлалын төв	үндэсний товчоо		
Хүүвэр Институшн			Гадаад харилцааны зөвлөл	Шинэ Америк сан	Төсөв, Бодлогын Тэргүүлэх чиглэлийн төв
Дэвшил ба Эрх Чөлөө Сан			Эрх чөлөө форум	Карнегийн олон улсын энх тайвны сан	Олон нийтийн ёс зүйн төв
Манхатган хүрээлэн			Эдийн засгийн стратегийн хүрээлэн		Улс төр, Эдийн засгийн судалгааны нэгдсэн төв
Өрсөлдөөнт бизнесийн хүрээлэн			Прогрессив бодлогын хүрээлэн		Уорлдвач Хүрээлэн
Гэр бүлийн судалгааны зөвлөл			Калифорнийн төрийн бодлогын хүрээлэн		Батлан хамгаалах мэдээллийн төв
Бодлогын шинжилгээний үндэсний төв			Ирээдүйн төлөө нөөц		Бодлогын судлалын хүрээлэн
			Бэйкэр хүрээлэн		Эдийн засгийн бодлогын хүрээлэн

(McGann, 2005)

Хүргэх суваг

Тинк танкууд нь өөрийн үйл ажиллагааг Конгрессийн гишүүд, шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчдад янз бүрийн байдлаар хүргэдэг.

Арга хэмжээ зохион байгуулах- Тинк танкууд семинар, бага хурал, лекц, дугуй ширээний ярилцлагыг байнга зохион байгуулж байдаг. Тухайлбал, Стратеги, олон улс судлалын төвийн вэб сайт дээр жилд 2000 гаруй арга хэмжээ зохион байгуулдаг гэжээ. (<https://www.csis.org/>)

Нийтлэл- Ихэнх тинк танкууд өөрийн гэсэн сэтгүүл, товхимол, өгүүлэл, зөвлөмж, мөн мультимедиа нийтлэл гаргадаг байна. Карнегийн олон улсын энх тайвны сан гэхэд л Гадаад бодлого (Foreign Policy) сэтгүүлийг Гадаад харилцааны зөвлөлөөс Гадаад хэрэг (Foreign Affairs)

Тинк танкуудын зохион байгуулалтсэтгүүлийг хоёр сар тутамд гаргадаг байна. Сэтгүүлээс гадна судалгааны тайлан, ном, нэг сэдэвт бүтээл, видео зэргээс гадна бүх тинк танкууд вэбсайт, вэблог, имэйл жагсаалтыг идэвхтэй хэрэглэдэг.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй нягт хамтарч ажилладаг. Ихэнх тинк танкуудын судлаач, мэргэжилтнүүд голлох ТВ-ийн нэвтрүүлэг, шоунд байнга оролцдог, сонины голлох нийтлэл, редакцийн зурвас бэлтгэхээс гадна байнга зочин экспертээр оролцож санал, дүгнэлтээ хуваалцдаг байна.

Төрийн байгууллагатай нягт хамтран ажилладаг. Тинк танкийн экспертүүд Конгрессийн сонсголд оролцдог, гишүүдэд мэдээлэл, дүгнэлтээ өгөхөөс гадна гишүүд, төрийн албан хаагчдын тинк танкийн арга хэмжээ, хурал, семинарт урьж мэдээлэл солилцох туршлага түгээмэл ажээ. Гишүүдийн хувьд ч өөрийн саналыг урьдчилаад шалгахын тулд тинк

танкуудтай уулзах, зөвлөлдөх, хараат бус шинжээчдийн шүүлтүүрээр оруулах сонирхол их байдаг байна.

Хуулиараа тинк танкууд тодорхой хуулийн төслийн талаар нөлөөлөл үзүүлэхийг хориглодог ч томоохон бодлогын асуудлаар тинк танкуудын нөлөө хүчтэй байдаг гэж үздэг. Учир нь тинк танзууд бодлогын чиглэлийн талаар сүлжээ, эвсэл байгуулах, ижил сонирхолтой, үзэлтэй талуудыг холбох чухайл үүрэгтэй байдаг нь тэдгээрийн үр нөлөөг нэмэгдүүлж байдаг. Энэ холбоо сүлбээний ачаар тинк танкуудаас олон хүмүүс Гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалын салаа мөчирт орж ажиллах нь нийтлэг байдаг.

Сонирхуулах үүднээс дэлхийн улсуудын тинк танкуудын тоог 2016 оны байдлаар харьцуулан үзүүлбэл ийм байна.

	Улс	Тинк танкийн тоо
1	АНУ	1835
2	БНХАУ	435
3	ИБУИНВУ	288
4	Энэтхэг	280
5	ХБНГУ	195
6	Франц	180
7	Аргентин	138
8	ОХУ	122
9	Япон	109
10	Канад	99
11	Итали	97
12	Бразил	89
13	ӨАБНУ	86
14	Швед	77
15	Швейцарь	73
16	Австрали	63

Эх сурвалж. McGann, 2016 *Global Go Think Tank Index Report*. 2017

Санхүүжилт

Санхүүжилтийн хувьд нээлттэй, хувийн сан, корпораци, хувь хүн, засгийн газрын санхүүжилт, гэрээний төлбөр, гадны засгийн газар гэх мэт олон эх үүсвэртэй байдаг. Ийнхүү нээлттэй байхын цаад нэг эх үүсвэрээс хараат бус байх эрмэлзэлтэй холбоотой. АНУ, Канадад татвараас чөлөөлөгддөг.

Дүгнэлт

АНУ-ын бодлого боловсруулах үйл явц дахь тинк танкуудын үүрэг нь түүхэн хувьслын явцад зөвхөн бодлогын шийдэл боловсруулах, түүнийг сурталчлах, нөлөөлөхөөс илүү өргөн хүрээнд хөгжиж иржээ.

Сонгуулиар нэг намаас нөгөө улс төрийн хүчинд эрх мэдэл шилжих үед тинк танкуул боловсон хүчний сэлбэлтийн чухал үүрэг гүйцэтгэж байна. Сөрөг хүчинд шилжсэн намын боловсон хүчин, экспертүүд тинк танкууд байршиж, мэргэжсэн судалгаа, ажлаа үргэлжлүүлэн хийх, мөн засгийн газрын явуулж буй бодлогыг бодитой, үр дүнтэй шүүмжлэх, алтернатив хувилбарыг дэвшүүлж байдаг. Хэвлэл мэдээлийн хэрэгсэлтэй идэвхтэй хамтарч ажилласнаар эдгээр алтернатив хувилбар болон засгийн газрын бодлогыг харьцуулах, дэнслэх боломж үүсч, мэдээллийн хэрэгслийн хувьд илүү хүчтэй, чанартай байж, дөрөвдэх засаглалын үүргээ гүйцэтгэх боломж илүү бүрддэг байна. Товчхон хэлэхэд, сөрөг хүчин нь тинк танк, медиагаар дамжуулан сүүдрийн засгийн газрын үүргийг гүйцэтгэдэг ажээ.

Үүний ачаар сонгуулиар эрх мэдэл солигдсон ч засгийн газар мэргэжлийн удирдлагын шилжилт саад багатай явагдаж, медиа контент сайжирч, иргэдэд бодитой мэдээлэл очиж, улс төрийн хэлэлцүүлэг нь хувь хүн гэхээсээ илүүтэй тодорхой бодлогын шийдэлд түлхүү анхаарах улс төрийн соёлыг төлөвшүүлдэг ажээ.

Иймд манай улсын хувьд ч гэсэн энэ жишгийг харгалзан үзэж, тинк танкуудыг хөгжүүлэх, одоо байгаа судалгааны байгууллага, хувийн байгууллагуудын мэдээлэл, датаг нээлттэй хуваалцдаг, хэвлэн нийтэлдэг, бодлогын судалгаанд хэрэглэдэг байх, хэвлэл мэдээллийн байгууллагууд энэ чиглэлээр дээрх байгууллагуудтай хамтран ажилладаг байх нь чухал юм.

Судалгааны байгууллагуудын хувьд ч мөн хурдтай байх, тулгамдсан асуудлаар богино хугацаанд шийдэл санал болгох чадамжийг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний өндөр түвшинд гэхээсээ илүү шийдвэр гаргагчид болон олон нийтийн хувьд энгийн, хялбар байдлаар томёологдсон дүгнэлт, тайлбар гаргаж хэвших нь оновчтой юм.

Төсөв санхүүгийн хүндрэлтэй өнөөгийн нөхцөлд шинээр судалгааны бүтэц байгуулах гэхээсээ илүү одоо байгаа судалгааны байгууллагын судалгааг олж нэгтгэх, томоохон компаниуд, банкууд, санхүүгийн байгууллагуудын судалгаа, дүн шинжилгээг нэгтгэх, энгийн хэлнээ буулгах, судалгааны дата бүхий газруудын дүнг нэгтгэн буулгадаг бүтцийг хөгжүүлбэл бэлээнээ хийгддэг судалгааг бодит бодлогын шийдэл боловсруулахад ашиглах боломж нээгдэх юм.

Ашигласан материал

James McGann, *2016 Global Go Think Tank Index Report* University of Pennsylvania, 2017.

James G. McGann, *Think Tanks and Policy Advice in the US*, University of Pennsylvania, 2005.